



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/167

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэлийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын жагсаалт, зураг төсөл болон барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан ажлын төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулж танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Сүхбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020000904

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 14-ны өдрийн
№1487 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц,
үйлдвэр, технологийн паркийн асуудал
хариуцсан орлогч;

Гишүүд:

-Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын
дарга;

-Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн
дарга;

-Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны
орлогч дарга;

-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын
Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга;


-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын
Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн
дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
барилга, орон сууцны бодлого төлөвлөлт
хариуцсан мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 14-ны өдрийн
11/02 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.01.24

Улаанбаатар хот

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах		Ажлын хэсгийн дарга
2	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын жагсаалт гаргах	Ажлын 7 хоногт	Ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
3	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулах	Ажлын 7 хоногт	Ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
4	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулах	Ажлын 7 хоногт	Ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
5	Ажлын хэсгээс гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргад танилцуулах		Ажлын хэсгийн дарга